



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/663

Зуунмод

Малд үзлэг, ангилалт явуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.1, 16.8.4, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А\473 тоот тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баталгаажсан үүлдэр, омгийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэлт явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Гантулга- Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Нарийн бичгийн дарга:

М.Туяа- Хүнс, Хөдөө аж ахуйн газрын албаны дарга

Гишүүд:

С.Тулга- Хүнс, Хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Х.Түвшинсанаа- Мал үржлийн хяналтын улсын байцаагч

Сумдын Засаг дарга нар

Мал үржүүлэг, технологийн нэгжүүд

2.Бог малын хээлтүүлэгчид үзлэг, ангилалт явуулах, баталгаажуулах ажлыг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангаж ажиллахыг ажлын хэсэг (Н.Гантулга)-т үүрэг болгосугай.

3.Сумдад үзлэг ангилалт зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг сум бүр сумын Засаг даргын захирамжаар томилон ажиллуулж, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж ажиллахыг сумдын Засаг дарга, Мал үржүүлэг технологийн нэгжид даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР



4123911733



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/666

Зуунмод

“Шүд угаах олимпиад” зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бага насны хүүхдийн шүд амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шүд угаах зөв аргачлалыг эзэмшүүлэх, шүд угаахын ач холбогдлыг олон нийтэд таниулах зорилготой “Шүд угаах олимпиад”-ыг Зуунмод сумын ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.“Шүд угаах олимпиад”-ыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган, үр дүнтэй зохион байгуулахыг “Ажлын хэсэг” (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

3.“Шүд угаах олимпиад”-ыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, үр дүнг тооцож, тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа) нарт даалгасугай.

4.“Шүд угаах олимпиад”-дад оролцох багш, суралцагчдыг дэмжин, хичээлийн тасалдалгүй, цагийн зохицуулалт хийж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа), Зуунмод сумын Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 03 -ны өдрийн А/666 дүгээр  
захирамжийн ? хавсралт

**“ШҮД УГААХ ОЛИМПИАД”ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Мөнхцэцэг (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын  
хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн дэд ахлагч:

С.Мөнхтуяа (Эрүүл мэндийн газрын дарга)

Ц.Нарантуяа (Боловсрол шинжлэх ухааны газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Н.Энхтайван (Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга)

Г.Сувдаа (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Э.Лхагвадулам (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Э.Ганхуяг (Төрийн үйлчилгээ мэдээллийн төвийн ахлах  
ажилтан)

Л.Эрдэнэцэцэг (Хүмүүн цогцолбор сургуулийн захирал)

Д.Хунтогос (4 дүгээр сургуулийн захирал)

Д.Хуягбаатар (5 дугаар сургуулийн захирал)

Т.Нямсүрэн (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл  
мэндийн хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Т.Баасанхүү (Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл  
мэндийн хэлтсийн мэргэжилтэн)

Ө.Хишигдолгор (Боловсрол, шинжлэх ухааны газрын Сургалт арга  
зүйн хэлтсийн мэргэжилтэн)



## ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/667

Зуунмод

### “Нээлттэй Төв аймаг” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээ авах тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллах, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг дэмжих болон аймгийн хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нээлттэй Төв аймаг”, “Нэг сум-Нэг бүтээгдэхүүн” арга хэмжээг 2023 оны 10 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд Төв аймгийн Зуунмод хотод зохион байгуулсугай.

2. “Нээлттэй Төв аймаг” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. “Нээлттэй Төв аймаг” нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлын төлөвлөгөө болон хөтөлбөрийг боловсруулан батлуулж, товлосон хугацаанд өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсэг (Г.Сурмаа, Н.Гантулга)-т даалгасугай.

4. Нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд аймаг, орон нутгийн давуу тал, боломжийг гаргах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төслүүдэд шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулагчдын идэвх оролцоонд тулгуурлан бэлтгэл, зохион байгуулалтыг сайтар ханган зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга нар (Г.Сурмаа, Н.Гантулга), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

4123011747

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 03 -ны өдрийн А/667 дүгээр  
захирамжийн хавсралт

Нэг. "Нээлттэй Төв аймаг" арга хэмжээ  
зохион байгуулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн дарга:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Ажлын хэсгийн дэд дарга:

М.Отгонбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Д.Саран-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ю.Бямбацогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

С.Магнайбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Д.Мөнхцэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Т.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга)

Б.Ганхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Батцэцэг (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Б.Насанжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Ж.Даш-яйчил (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Д.Батжаргал (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Ц.Нарантуяа (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Б.Тунгалаг (Соёл, урлагийн газрын дарга)

С.Мөнхтуяа (Эрүүл мэндийн газрын дарга)

Н.Энхбат (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

М.Буянхишиг (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Д.Намсрайноров (Монгол туургатан театрын дарга)

С.Цогбаяр (Үйлчилгээний нэгдсэн төвийн дарга)

Т.Ариунболд (Мэдээлэл, холбоо сүлжээ ТӨҮК-ийн Төв аймаг дахь салбарын дарга)

Л.Гансүх (УБЦТСүлжээ ТӨХК-ийн Ашиглалт, засварын Зуунмод төвийн дарга)

Ж.Эрдэнэжаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)
Б.Оюунцэцэг	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)
А.Хажидмаа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)
Н.Хорлоо	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
Э.Баярбат	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлчилгээний албаны дарга)
Э.Ганхуяг	(Төрийн үйлчилгээний мэдээллийн төвийн Ахлах ажилтан)
Ц.Баярмагнай	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
П.Дэмчигжав	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Н.Жанлуусүрэн	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Цэрэнлхагва	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Баярмаа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Довдонцэрэн	(Төв аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн ажилтан)
Г.Мөнхзаяа	(Төв аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн ажилтан)
	(Сумдын Засаг дарга нар)
Нарийн бичгийн дарга:	
А.Туяажаргал	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан Ахлах мэргэжилтэн)
Ц.Ууганбаатар	(Төв аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга)

Хоёр. "Нэг сум-Нэг бүтээгдэхүүн" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн дарга:	
Н.Гантулга	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Ажлын хэсгийн дэд дарга:	
Д.Батсайхан	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга)
Ажлын хэсгийн гишүүд:	
Ч.Сарангэрэл	(Зуунмод сумын Засаг дарга)

Б.Болдбаатар	(Мал эмнэлэгийн газрын дарга)
Н.Доржбалжид	(Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа)
А.Шаравнямбуу	(Зуунмод сумын Хот тохижуулах газрын дарга)
Б. Батболд	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Х. Түвшинжаргал	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга)
М.Ганчимэг	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын албаны дарга)
М.Туяа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)
Х.Түвшинсанаа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал үржлийн хяналтын Улсын байцаагч)
Б.Түмэнжаргал	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын улсын байцаагч)
Б.Оюунжаргал	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Б.Хишигтогтох	(Стандарт хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Г.Цоггэрэл	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
Б.Баяраа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
Б.Цэрэнгомбо	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
Б.Уянга	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
С.Саранмандал	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
Т.Отгонсүрэн	(Мал эмнэлэгийн газрын мэргэжилтэн)
Л.Ундрахбаатар	(Мал эмнэлэгийн газрын улсын байцаагч)
Ж.Дорж	(Мал эмнэлэгийн газрын мэргэжилтэн)
А.Батхонгор	(Мал эмнэлэгийн газрын мэргэжилтэн)
М.Тэмүүлэн	(УБЦТС Зуунмод хэрэглэгчдэд үйлчлэх төвийн техникч)
Н.Дунхорол	(Аймгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн)
Нарийн бичгийн дарга	
Ж.Батчимэг	(Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
С.Ганчимэг	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн албаны дарга)

\_\_\_оОо\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/670

Зуунмод

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 6.3.1.3 дахь заалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга

Б.Ганхуяг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд

Б.Батжаргал

(Орон нутгийн өмчийн газрын дарга)

Б.Саруул

(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга)

Ч.Сарангэрэл

(Зуунмод сумын Засаг дарга)

Ж.Эрдэнэжаргал

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Ц.Баярмагнай

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

С.Ганболд

(Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын Улсын Ахлах байцаагч)

Д.Алтансүх

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга

Б.Мөнхбаяр

(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Хяналт шалгалтын тайланг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор тайлагнахыг ажлын хэсэг (Б.Ганхуяг) гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/673

Зуунмод

Хяналт шалгалтын ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд Амьтны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох бусад хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт явуулах ажлын хэсгийн удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хяналт шалгалт зохион байгуулахад шаардлагатай шатахууны тооцоог хоёрдугаар хавсралт хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналт шалгалтын арга хэмжээнд шаардагдах 552,000 (таван зуун тавин хоёр мянга) төгрөгийн зардлыг аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн 2023 оны 10 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ж.Даш-Яйчил)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР

**ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН УДИРДАМЖ**

2023.08.12

Зуунмод

Зорилго: “Байгаль орчныг хамгаалах тухайхууль, “Амьтны тухай” хууль Монгол улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилтийг хангуулах, Аймгийн нутаг дэвсгэр дээр идлэг шонхор бариулахаар Төв аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт, шалгалт хийх, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арилгуулах, зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангахад хяналт шалгалтын зорилго оршино.

Ажлын хэсгийн ахлагч:

Ж.Даш-Яйчил (Байгаль орчин, Аялал Жуулчлалын газрын дарга)

Гишүүд:

Ц.Очирхуяг (Ойн нэгжийн дарга)

С.Эрдэнэцогт (Уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Н.Шинэбаяр (Биологийн төрөл зүйлхариуцсан мэргэжилтэн)

Ж.Отгонбуян (Байгаль орчин, Хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Цэрэндовдон (Аймгийн Цагдаагийн газрын Экологийн цагдаа)

Хамрах хүрээ:

Төв аймгийн Баян, Сэргэлэн, Бүрэн сумдын нутаг дэвсгэрт идлэг шонхор шувуу барихаар байрласан отгууд, Баянцагаан, Баян-Өнжүүл, Алтанбулаг сумдын нутгаар эргүүл хийнэ.

Ажлын чиглэл:

1. Монгол улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоолоор баталсан 2023 онд соёлын зориулалтаар гадаад улсад гаргах идлэг шонхор шувууны тоо хэмжээний хязгаарт багтаан олгосон Аймгийн нутаг дэвсгэрт идлэг шонхор шувуу барих тусгай зөвшөөрлийн дагуу Баян, Сэргэлэн, Бүрэн сумдын нутагт байрласан отгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх.

2. Монгол улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоолд заасан гадаадад гаргах идлэг шонхор шувууны тоо хэмжээнд багтсан эсэхэд шалгалт хийх.

3. БОАЖСайдын А-299 тоот тушаалаар баталсан журмын биелэлт зэргийг шалгаж журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах.

4. Төв Аймгийн Байгаль орчин, Аялал Жуулчлалын газартай байгуулсан гэрээний хэрэгжилт, болон зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл ашиглаж байгаа эсэх.

5. Усны тухай хууль, дүрэм, журам, стандартын мөрдөж буй эсэх, төлбөр төвлөрүүлсэн эсэх;

6. Хог хаягдлын тухай 9 дүгээр зүйлийн 9.4.1 заалт Хог хаягдлыг төвлөрүүлэх цэг, Хог хаягдлын хураамж хог хаягдлын гэрээ хийсэх эсэх;

7. Газрын тухай хуулийн 44 зүйлийн дагуу түр байрлах цэгийн зөвшөөрөл авсан эсэхийг шалгах;

8. Төв аймгийн Засаг даргын олгосон зөвшөөрлийн дагуу өгөөшний тоо хэмжээнд буй эсэхэд хяналт шалгалт хийх;

9. Зөвшөөрөлгүй галт зэвсэг авч яваа эсэх;

10. Сум орон нутагтай хэрхэн хамтарч ажиллах талаар мэдээлэл авах;

Хугацаа:

2023 оны 10 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд3 хоног ажиллана.

Маршрут-1: Зуунмод-Сэргэлэн 18 км, Сэргэлэн суманд 70 км, Сэргэлэн- Баян 70км, Баян суманд шалгалт хийх 100 км, Баян- Баянцагаан 67 км Баянцагаан суманд 100 км, Баянцагаан-Зуунмод 112км

Маршрут-23уунмод-Баян-өнжүүл 131км, Баян-Өнжүүл суманд шалгалт хийх 100км, Баян-өнжүүл-Бүрэн 95км, Бүрэн суманд шалгалт хийх 100км, Бүрэн-Алтанбулаг 141км, Алтанбулаг суманд шалгалт хийх 100км, Алтанбулаг-Зуунмод 51км

№	Машины төрөл	Шатахуун зарцуулалт 100 км-т	Шатахууны нэгж үнэ /Аи92/	Нийт явах км	Шаардлагатай шатахуун /литр/	Нийт зардал /төг/
1	22-80 ТӨВ улсын дугаартай, Фургон маркын машин	18 литр	2440	1255	226	552,000

Дүн мэдээ гаргах:

Ажлын хэсэг хяналт, шалгалт хийж дууссанаас хойш, ажлын 3 хоногийн дотор шалгалтын дүн мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргад танилцуулна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
МЭРГЭЖИЛТЭН *Н.Шинэбаяр* Н.ШИНЭБАЯР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 05 -ны өдрийн А/673 дүгээр захирамжийн 2 дугаар хэвсрэлт

ХЯНАТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТӨСӨВ

2023.10.01

Зуунмод

№	Гарах	Хүрэх	км	Ажлын төлөвлөгөө
1	Зуунмод	Сэргэлэн	18	Хяналт шалгалт хийх
	Сэргэлэн суманд		70	Гадаадын иргэнд идлэг шонхор бариулах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
2	Сэргэлэн	Баян	70	Хяналт шалгалт хийх
	Баян суманд		100	Гадаадын иргэнд идлэг шонхор бариулах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
3	Баян	Баянцагаан	67	Хяналт шалгалт хийх
	Баянцагаан суманд		100	Гадаадын иргэнд идлэг шонхор бариулах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
4	Баянцагаан	Зуунмод	112	Хяналт шалгалт хийх
5	Зуунмод	Баян-өнжүүл	131	Хяналт шалгалт хийх
	Баян-өнжүүл суманд		100	Гадаадын иргэнд идлэг шонхор бариулах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
6	Баян-өнжүүл	Бүрэн	95	Хяналт шалгалт хийх
	Бүрэн суманд		100	Гадаадын иргэнд идлэг шонхор бариулах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
7	Бүрэн	Алтанбулаг	141	Хяналт шалгалт хийх
	Алтанбулаг		100	Гадаадын иргэнд идлэг шонхор бариулах үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх
8	Алтанбулаг	Зуунмод	51	Хяналт шалгалт хийх
	Нийт		1255км	

ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХЭД ШААРДЛАГАТАЙ ШАТАХУУНЫ ТООЦОО

2023.08.01

Зуунмод

№	Машины төрөл	Шатахуун зарцуулалт 100 км-т	Шатахууны эгжүнэ /Аи92/	Нийт яв ахкм	Шаардлагатай шатахуун /литр/	Нийт зардал /төг/
1	22-80 ТӨВ улсын дугаартай, Фургонмаркын машин	18 литр	2440	1255	226	552,000

ТООЦОО ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН *Н.Шинэбаяр*

Н.ШИНЭБАЯР

ХЯНАСАН: ТӨСВИЙН АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН

Б.ЭРДЭНЭЖАРГАЛ



## ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/681

Зуунмод

### Гоц халдварт шүлхий өвчнөөс Урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтын ажлыг эхлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2, Засгийн газрын Х хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын 03 албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг зураглалын дагуу 2023 оны 10 дугаар сарын 05-наас 10 дугаар сарын 25-ны өдрийн хороонд зохион байгуулсугай.

2.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд тус өвчинд мэдрэмтгий үхэр, сарлаг, гахайг вакцинжуулалтад хамруулах малын тоо, биобэлдмэлийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Мал эмнэлгийн газар (Б.Болдбаатар)-т ДААЛГАХ нь:

3.1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хуваарийн дагуу сумдад олгон, хүйтэн хэлхээний идэвхийг нь бууруулахгүй байхад онцгой анхаарч, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр ханган, дархлаажуулалтын ажлын явц, гүйцэтгэлд ажлыг хэсэг томилон хяналт тавин ажиллах

3.2.Вакциныг баталсан хуваарийн дагуу тэмдэглэгээ хийн мал эмнэлгийн тасагт олгож, хоосон шилийг тоо ёсоор тулган хүлээн авч зарцуулалтын тооцоо хийх

3.3.Дархлаажуулалтын ажилд хариуцлагагүй хандсан, хангалтгүй ажил үйлчилгээ үзүүлсэн сумын удирдлага, мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал, малын эмч, малчдад хуулийн дагуу хариуцлага тооцох

4.Онцгой байдлын газар (Б.Эрдэнэбат)-т ДААЛГАХ нь:

4.1.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын үед сумын онцгой комисс, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг татан оролцуулах, туслах ажилтны хүн хүчний асуудлыг шийдвэрлэх

5.Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т ДААЛГАХ нь:

5.1.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийж буй хугацаа болон дархлаа тогтох хүртэлх 28 хоногийн хугацаанд аймгийн хэмжээнд үхэр, гахайг амьдаар тээвэрлэх, шилжилт хөдөлгөөнийг бүрэн хориглон сум, орон нутгийн хэсгийн төлөөлөгч, цагдаа мөн хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдад мэдээллийг хүргэн, хяналтыг сайжруулж ажиллах

4123011776

6.Сумын Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

6.1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийх ажлын хэсгийг томилон, группийн явах маршрут, зураглал, вакцин тарих малчин өрхийн жагсаалтыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж бүрээр гаргах

6.2.Хүйтэн хэлхээний горимыг баримтлан нэг шил вакциныг задалснаас хойш 10 цагийн дотор тарьж дуусгах, айл өрх орхигдуулахгүйгээр сумын хилийн цэсээс төв рүү чиглэлтэйгээр тарих, хоосон шилийг шатааж хаяхгүйгээр тоо ёсоор буцаан Мал эмнэлгийн газарт хүлээлгэн өгөх

6.3.Орон нутгийн хэмжээнд дархлаажуулалтын ажлыг шуурхай үр дүнтэй зохион байгуулахын тулд туслах ажилтан, мал баригчаар дүйцүүлэхийн албан хаагчдыг дайчлах, малчны бүлэг, хоршоог нэгдсэн зохион байгуулалтад оруулах,

6.4.Дархлаажуулалтын мэдээг Мал эмнэлгийн нэгдсэн системээс өдөр бүр татаж авах тул Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар тарьсан айлынхаа малын мэдээллийг тухайн сууриас өдөр бүр оруулж байгаад хяналт тавьж, албан үүргээ гүйцэтгэхгүй байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт хариуцлага тооцох

6.5. Тарилгын явц, гүйцэтгэлд багийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн вакцинжуулалт хийсэн байдлыг шалгаж илэрсэн зөрчлийг тухай бүр аймгийн Мал эмнэлгийн газарт мэдээлж, холбогдох арга хэмжээ авч тухай бүр шийдвэрлүүлэх

6.6.Тарилга хийсэн тухай материалыг журмын дагуу бүрдүүлж, Мал эмнэлгийн газарт ирүүлэх 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор багтаан ирүүлэх

7.Багийн Засаг дарга нарт ДААЛГАХ нь:

7.1.Малчин, мал, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчдөд дархлаажуулалтын товыг зарлан мэдээлж, дархлаажуулалтад хамрагдах малыг бүрэн бэлдүүлэх

7.2.Малын эмчийн аюулгүй байдлыг ханган, малчнаар малыг барьж бэхлүүлэн тарилгыг гүйцэтгүүлэх

8.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 05 -ны өдрийн А/681 дүгээр  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ШҮЛХИЙН ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

2023.10.05

Зуунмод

№	Сумын нэр	МЭҮН-ийн нэр	Тарих малын тоо			Олгох тун
			Үхэр	Гахай	Нийт	
1	Алтанбулаг	Өгөөж хангай	8550	50	8600	8600
2		Алтанбулагийн Таргил	8550		8550	8600
3		Дэлгэрэх эрдэнэт сүрэг	8550	1200	9750	9700
Нийт			25650	1250	26900	26900
4	Аргалант	Аргалант тахь	4800	100	4900	4900
5		Орлой мэргэн	5000	100	5100	5100
Нийт			9800	200	10000	10000
6	Архуст	Нар-Уст	3100		3100	3100
7		Хөдөө бүрд	4500		4500	4500
Нийт			7600	0	7600	7600
8	Батсүмбэр	Хүй	20500	30	20530	20500
9		Ивомек	11000	46	11046	11100
10		Чандмань оточ	7100		7100	7100
Нийт			38600	76	38676	38700
11	Баян	Бамбар-Уул	4350		4350	4300
12		Чулуун солонго	4850		4850	4800
Нийт			9200		9200	9100
13	Баяндэлгэр	Дэлгэр баян-Уул	6520		6520	6500
14		Дэлгэр ажнай	10000		10000	10000
15		Дэлгэрбаян тал	4000		4000	4000
Нийт			20520		20520	20500
16	Баянжаргалан	Баян-Эрхтийн сүрэг	5300		5300	5300
17		Шинэ-Ус сүрэг	3800		3800	3800
18		Угалз-Ус ирээдүй	3500		3500	3500
Нийт			12600		12600	12600
19	Баян-Өнжүүл	Бүрд бараат хангай	2610		2610	2600
20		Дөмөнгийн цуурай	2610		2610	2600
21		Азай шувуутайн хөтөл	2915		2915	2900
22		Баянцээлийн хишиг	2915		2915	2900
23		Баян алтан овоо	2000		2000	2000
Нийт			13050		13050	13000
24	Баянхангай	Атар-Ирээдүй	2400		2400	2400
25		Хоньт хайрхан	3300		3300	3300
Нийт			5700		5700	5700
26	Баянцогт	Даргиат-Уул	2550		2550	2600

27		Хангинах	2500		2500	2500
28		Хөгжлийн түлхүүр таван эрдэнэ	2800	1000	3800	3800
29		Сонор эрдэнэт сүрэг	2700		2700	2700
Нийт			10550	1000	11550	11600
30	Баянцагаан	Зогсоол бүрд	4300		4300	4300
31		Чихэрт балуу	3049		3049	3100
32		Бумбат цагаан дэл	4600		4600	4600
33		Буман хүлэг	2300		2300	2300
34		Жийх дөрөө	2250		2250	2200
Нийт			16499		16499	16500
35		Чандмань алтан төл	6000		6000	6000
36		Бат эрүүл сүрэг	4500		4500	4500
Нийт			10500		10500	10500
37	Борнуур	Ихэр сүрэг	5300		5300	5300
38		Сүүж хад	5300		5300	5300
39		Байгаль болор	5300		5300	5300
Нийт			15900	0	15900	15900
40	Бүрэн	Түмий	3400		3400	3400
41		Баясгалан-Уул	3400		3400	3400
42		Сайн цохио	3000		3000	3000
43		Арцат баян гүн	3000		3000	3000
44		Баялаг сүрэг баян төхөм	3000		3000	3000
Нийт			15800		15800	15800
45	Дэлгэрхаан	Гүнхан билэгт	9000		9000	9000
Нийт			9000		9000	9000
46	Жаргалант	Жаргалант сүрэг	5800	400	6200	6200
47		Бат-Энх сүрэг	5400		5400	5400
48		Буурлын сүрэг	5800	200	6000	6000
49		Бяцханбулгийн буянт сүрэг	3700	600	4300	4300
Нийт			20700	1200	21900	21900
50	Заамар	Удмын сан	3000		3000	3000
51		Сэрүүн дэнжийн тал	8000	50	8050	8000
52		Номын хүч	7800	50	7850	7800
53		Оюун буян нутаг өгөөж	2900		2900	2900
54		Түмэн сүргийн өгөөж	4300		4300	4300
Нийт			26000	100	26100	26100
55	Зуунмод	Н Бэлэг	6500	200	6700	6700
Нийт			6500	200	6700	6700
56	Лүн	Хангай-Өлгий	2600		2600	2600
57		Уугий	1600		1600	1600
58		АДФ	2000		2000	2000
59		Хөшиг хангай	2100		2100	2100
60		Нөхөрлөл-Ирээдүй	1500		1500	1500
61		Аргал-Овоо	2500	200	2700	2700

		Нийт	12300	200	12500	12500
62	Мөнгөнморьт	Үржих гал	15000		15000	15000
63		Мөнх идэр хайрхан	16500	20	16520	16500
		Нийт	31500	20	31520	31500
64	Өндөрширээт	Баянтуул	2100		2100	2100
65		Уламмандах	3800		3800	3800
66		Уянгын сүрэг	7100	100	7200	7200
		Нийт	13000	100	13100	13100
67	Сэргэлэн	Гурван хангай	5000		5000	5000
68		Жаран дөлгөөн	2950		2950	3000
69		Эрдэнэ буман	400		400	400
70		Өөлд сөдгий	2600		2600	2600
71		Сүлд манал	2022		2022	2000
		Нийт	12972		12972	13000
72	Сүмбэр	Агран	5624	40	5664	5700
		Нийт	5624	40	5664	5700
73	Угтаалцайдам	Буянт-Угтаал	4100		4100	4100
74		Өвөр бүрэг	2700		2700	2700
75		Тэрэм төв	5000	300	5300	5300
		Нийт	11800	300	12100	12100
76	Цээл	Түмэн-Ажнай	8150		8150	8100
77		Төгс дарь ганга	5450		5450	5500
		Нийт	13600		13600	13600
78	Эрдэнэ	Цэмбэл	12400		12400	12400
79		Цэмбэл-Эрдэнэ	12300		12300	12300
80		Цэмбэл мөнх	5200		5200	5200
		Нийт	29900		29900	29900
81	Эрдэнэсант	Их холбоо	3600		3600	3600
82		Батхаан анимэл хэйлт	3600	200	3800	3800
83		Баян бөөр	3600		3600	3600
84		Сүргийн рашаан	3600		3600	3600
85		Эм рашаан	3600		3600	3600
		Нийт	18000	200	18200	18200
		Аймгийн дүн	422865	4886	427751	427700

БОЛОВСРУУЛСАН:

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН  
АЛБАНЫМЭРГЭЖИЛТЭН

Ч.ЯНЖИН

**ШҮЛХИЙӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**НЭГ.ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО**

- 1.Хил даван халдварладаг, мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний тохиолдол 2023 онд 1 аймгийн 1 суманд 4 голомт бүртгэгдсэн.
- 2.Сүргийн төвшний халдварлалтыг тогтоох тандалт судалгааны дүнгээр 3 өрх тутмын 1 нь шүлхий өвчний халдварт өртсөн.
- 3.Үхэр, гахай нь шүлхий өвчний халдвар тархаах хамгийн өндөр идэвхтэй байдаг /судалгаагаар нэг үхэр нь 3 малд, 3 үхэр нь 9 малд халдварыг дамжуулах идэвхтэй/
- 4.Үхэр нь шүлхий өвчинд хамгийн мэдрэмтгий, өвчний шинж тэмдэг нь хурц тод илэрдэг зэргийг харгалзан сүргийн дотор уг өвчний халдвар тархах эрсдэл, улсын хэмжээнд шүлхий өвчний тархалтыг бууруулах, зогсоход чиглэсэн нь энэхүү ажлын үндэслэл, зорилго болно.

**ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА**

- 1.Дархлаажуулалтын арга хэмжээнд 27 сумыг хамруулан 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс нэгдсэн байдлаар 20 хоногийн хугацаанд шуурхай хэрэгжүүлэх

**ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР, ХАМРАГДАХ МАЛ**

- 1.Дархлаажуулалтанд 27 сумыг хамруулах
- 2.Нийт үхэр, сарлаг, гахайг хамруулан гүйцэтгэх

**ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА**

- 1.Сумын мал эмнэлгийн тасаг нь тухайн сумын хэмжээнд дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, зураглал гаргах, гүйцэтгэлийг үнэлэх
- 2.Мал эмнэлгийн нэгж, гэрээт малын эмч нь тарилгын арга хэмжээг хууль, тогтоомж, заавар зааварчилгааны дагуу гүйцэтгэх

**ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ**

- 1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх “арриак вак” эсийн өсгөвөрт, идэвхгүйжүүлсэн, цийдмэг вакциныг хэрэглэх заавар, МЭЕГ-ын даргын баталсан стандарт ажиллагааны заавар /САЗ/ -г баримталж тарилгын арга хэмжээг гүйцэтгэнэ.
- 2.Тарилгад сумын хэмжээний нийт үхэр, сарлаг, гахайг нэг тунгаар тарина.
- 3.Аймгийн МЭГ, сумын МЭТ-аас тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавихаар томилогдсон ажлын хэсэгт вакцины заавар, зөвлөмжийг сайтар танилцуулах
4. Хяналтын ажлын хэсэг нь вакцины хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн горим зөрчигдөж байгаа эсэх, тарилгын явцад технологийн алдаа гарч байгаа эсэх, орхигдсон айл өрх, мал байгаа эсэх, тарилгын зураглалын дагуу гүйцэтгэж байгаа эсэх, тухайн суурийн малд эмнэлзүйн үзлэг хийж байгаа эсэхийг сайтар нягтлах.
- 5.Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, тархвар зүйч нар тухайн орон нутгийн шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтад хамрагдсан өрхүүдэд үйл ажиллагааны хяналт шалгалтыг газар дээр нь хийнэ. Үүнд:
  - 5.1.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид хувиарлагдсан вакцины тоо, хэмжээ, тэмдэглэгээ, хэвийн хорогдол, зарцуулалтад хяналт тавина.
  - 5.2.Тарилгын акт, цуваа, өрхийн эрүүл мэндийн дэвтэрт хяналт хийж тэмдэглэл үйлдэнэ.
  - 5.3.Вакцины хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлд хяналт тавьж, зургаар баталгаажуулна.
  - 5.4.Шаардлагатай тохиолдолд малчин өрхийн малын тоо толгойд хяналтын тооллого хийнэ.

5.5. Дархлаажуулалт хийсэн мэдээг Мал эмнэлгийн нэгдсэн системтэй тулгаж баталгаажуулна.

5.6. Дархлаажуулалтын дараа 5 хоногийн дотор мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон вакцины савыг тоо, хэмжээ, тэмдэг, тэмдэглэгээг хянан буцаан авч аймгийн Мал эмнэлгийн газарт хүргэнэ.

5.7. Дархлаажуулалтад ашиглаж буй тариурт хяналт хийж, вакцины үлдэгдэл гаргасан шалтгааныг тогтооно.

6. Дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цаг агаарын байдалтай холбогдуулан багийн гишүүдийн аюулгүй байдлыг сайтар хангасан байхаар арга хэмжээг зохион байгуулах

7. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зураглалыг сум болон багийн түвшинд гаргаж, зураглалын дагуу тарилгын ажлыг гүйцэтгэх /САЗ-д заасан/

8. Тухайн вакцины хэрэглэх заавар болон хадгалах, тээвэрлэх нөхцөлийн талаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт тусгайлан танилцуулж, гарын үсэг зуруулж, баталгаажуулах

9. Дархлаажуулалтын арга хэмжээнд хамрагдах өрх бүрийн гадна хашаа, саравчинд тарихаар зохион байгуулна. Тарилгын нэг цэгт 1-ээс дээш өрхийн малыг цуглуулж тарихыг хориглох

10. Вакциныг малчинд үлдээх, мал амьтан эмчлэх итгэмжлэлгүй этгээд, улсын байцаагчийн дүгнэлтгүй мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч, алдаа гаргасан малын эмч нар тарилга хийхийг хориглох, вакцинжуулсны дараа дахин өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэх;

11. Вакцинжуулалтын арга хэмжээний талаар зохих мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг малчдад өгөх;

12. Дархлаажуулалтын арга хэмжээнд автомат тариур хэрэглэхээс зайлсхийж аль болох нэг удаагийн тариур ашиглах, автомат тариур ашигласан тохиолдолд хий сорогдох, дутуу болон гадуур нь шахагдах зэрэг алдаанаас зайлсхийх, нэг өрхөд ашигласан тариурын зүүг дараагийн өрхөд ашиглахгүй байх, өрх бүрийн малыг дархлаажуулахын өмнө тодорхой тооны малд тарилга хийж алдаа гарч байгаа эсэхийг шалгах

13. Вакциныг малчинд үлдээх, мал, амьтан эмчлэх итгэмжлэлгүй этгээд, улсын байцаагчийн дүгнэлтгүй мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч, алдаа гаргасан малын эмч нар тарилга хийхийг хориглох, дархлаажуулсны дараа дахин өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэх

14. Дархлаажуулалтын арга хэмжээний талаар зохих мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг малчдад өгөх

15. Вакциныг хэрэглэх зааварт заасан дархлаа бүрэн дархлаа тогтох хугацаа /28 хоног/ хүртэл тарилгад хамрагдсан өрх нь отор нүүдэл хийхгүй байх анхааруулгыг малчдад өгөх /САЗ-д заасан/

16. Вакцинжуулалтын арга хэмжээнд малаа хамруулахаас татгалзсан болон бусад шалтгааны улмаас хамрагдаагүй өрх, малын судалгааг гарган аймгийн мал эмнэлгийн албанд даруй мэдэгдэж, нэгдсэн мэдээллийг зохих хяналтын байгууллагад хүргүүлж, холбогдох хуулийн дагуу арга хэмжээг тооцуулах;

17. Багийн Засаг дарга нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.8.1./товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулах/, 9.8.2./, амьтныг барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах/ заалтыг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчөөр гүйцэтгүүлж, хуулийн заалтыг мөрдүүлэх

#### ЗУРГАА. ТАЙЛАГНАХ

1. Дархлаажуулсан малыг ялган тэмдэглэх /малчдаар будаг бэлдүүлэх, будуулах, үс, ноосыг хяргах гэх мэтээр/, өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийх, Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд мэдээллийг малчны хотноос заавал оруулах, тарилгын явцад шүлхий болон бусад халдварт өвчний шинж тэмдгийн үзлэг, ажиглалтын арга хэмжээнд үхэр сүргээ бүрэн хамруулах шаардлагыг тавьж, хэрэгжүүлэх /САЗ-д заасан/

2. Дархлаажуулалтын ажлыг дүгнэхдээ малын тооны статистик мэдээлэл болон дархлаажуулалтад хамрагдсан малын мэдээллийг тулган нягтлах, зөрүү гарсан

тохиолдолд шалтгааныг тодруулж цахим системийн үр дүн оруулах хэсгийн тодруулга хэсэгт тэмдэглэх /САЗ-л заасан/

3.Аймгийн МЭГ-ын мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэнд дархлаажуулалтын өдөр тутмын болон нөхцөл байдлын мэдээллийг тарилгын эхэлсэн өдрөөс хойш цахимаар илгээсэн хүснэгтийн дагуу өдөр бүрийн 16:30 цагт багтаан илгээх

4.Аймгийн Мал эмнэлгийн газраас нэгдсэн журмаар олгосон цуваа, товчоо, актаар санхүүгийн баримтыг үйлдэх, тарилгын цуваа нэг бүрийн дүнг хянаж магадлах, малчдын тамгыг бүрэн даруулсан байх шаардлага тавих

5.Дархлаажуулалтын явцад гарсан зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, холбогдох арга хэмжээг хуулийн дагуу авч ажиллах

6.Тарилгын гүйцэтгэлд Мал эмнэлгийн улсын байцаагч технологийн хяналт тавьж ажиллах, дархлаажуулалтын ажлын илтгэх хуудас /нэгдсэн тайлан/-ыг Динамикаар ирүүлэх зэргээр тайлагнаж ажиллана.

7.Тарилга хийсэн тухай материалыг журмын дагуу бүрдүүлж, Мал эмнэлгийн газарт ирүүлэх 2023 оны 11 дүгээр сарын 15-ны дотор багтаан ирүүлэх

\_\_\_оОо\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/686

Зуунмод

Г Нөхөн сэргээлт хүлээн авах, хяналт Г  
шалгалтын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Заамар сумын нутагт ашигт малтмал олборлох, баяжуулах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан нөхөрлөл, ААНэгж, байгууллагад шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн удирдамжийг нэгдүгээр, 2023 оны нөхөн сэргээлт хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн удирдамжийг хоёрдугаар, хяналт шалгалт, нөхөн сэргээлт хүлээн авах ажлын хэсгийн зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналт шалгалтад шаардагдах 835,000 (найман зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хяналт шалгалтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 09 -ны өдрийн А/686 дүгээр  
захирамжийн 1 дүгээр хавсралт

Төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл:

Төв аймгийн Засаг даргаас өгсөн үүргэг чиглэлийн дагуу Төрийн хяналт шалгалтын тухай Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын стандартын мөрдөлтөд шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахад зорилго оршино.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектын нэр:

Төв аймгийн Заамар сумын нутагт ашигт малтмал олборлох, баяжуулах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан нөхөрлөл, ААНэгж, байгууллага шалгалтад хамрагдана.

Гурав. Шалгалтын төрөл, хэлбэр:

Төлөвлөгөөт бус шалгалт.

Дөрөв. Шалгалтын арга:

Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг газар дээр нь баримт бичигт нь тулган шалгах.

Тав. Шалгалтын бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Байгаль орчны хяналтын Улсын Ахлах байцаагч Ж.Даш-Яйчил

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэцогт

Гишүүд:

Төв аймаг дахь Тагнуулын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Эрдэнэ-Очир

Төв аймгийн Цагдаагийн газрын дэд дарга Цагдаагийн дэд хурандаа Г.Жанчив

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Ж.Отгонбуян

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Г.Билгүүн

Заамар сумын сум дундын цагдаагийн хэлтсийн Экологийн асуудал хариуцсан байцаагч Цагдаагийн ахлах дэслэгч Г.Тэмүүжин

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа:

Шалгалтыг 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах:

Шалгалтын дүнг бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан нөхөрлөл, ААНэгж, байгууллагад шалгалт хийж дууссанаас хойш ажлын 5 хоногт багтаан Засаг даргад танилцуулна.

\_\_\_оОо\_\_\_

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 09 -ны өдрийн А/686 дүгээр  
захирамжийн 2 дугаар хавсралт

Уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагуудын  
2023 оны техникийн болон биологийн нөхөн  
сэргээлт хүлээн авах удирдамж

Нэг. Зорилго, үндэслэл:

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тухайн жилийн Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлт түүн дотроо техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хүлээн авах, Тэр бум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд уул уурхайн аж ахуйн нэгж байгууллагуудад таригдсан моднуудыг хүлээн авахад зорилго оршино.

Хоёр. Хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектын нэр:

Төв аймгийн хэмжээнд ашигт малтмал олборлох, баяжуулах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага хамрагдана.

Гурав. Нөхөн сэргээлт хүлээн авах бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч:

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Байгаль орчны хяналтын Улсын Ахлах байцаагч Ж.Даш-Яйчил

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэцогт

Гишүүд:

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Оюун-Эрдэнэ

Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн М.Цогжавхаа

Тухайн сумын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

Тухайн сумын Байгаль хамгаалагч

Нутгийн иргэдийн төлөөлөл уурхай тус бүрийн орчны бүсэд амьдарч буй нэг иргэн

Дөрөв. Нөхөн сэргээлт хүлээн авах хугацаа:


2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Тав. Нөхөн сэргээлтийн дүн мэдээг танилцуулах;

Нөхөн сэргээлтийн дүн мэдээг аж ахуйн нэгж байгууллагуудаар явж ирсэнээс хойш ажлын 5 хоногт багтаан Засаг даргад танилцуулна.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 09 -ны өдрийн A/686 дүгээр  
захирамжийн 3 дугаар хавсралт



Явах чиглэл маршрут 1

№	Гарах	Хүрэх	км
Сумдаар явах чиглэл			
1.	Зуунмод	Заамар сум хайлааст баг	350
2.	Заамар суманд		300
3.	Заамар	Зуунмод	350
	Нийт		1000км

Авто машин: БОАЖГ-ын фургон 2292ТӨВ  
Нийт км, шатахуун 180 л А92 бензин 440000 төгрөг.

Явах чиглэл маршрут 2

№	Гарах	Хүрэх	км
Сумдаар явах чиглэл			
1.	Зуунмод	Сэргэлэн	15
2.	Сэргэлэн суман дотор		300
3.	Сэргэлэн	Баян	70
4.	Баян суман дотор		200
5.	Баян	Баянцагаан	70
6.	Баянцагаан суман дотор		30
7.	Баянцагаан	Алтанбулаг	120
8.	Алтанбулаг суман дотор		50
9.	Алтанбулаг	Зуунмод	45
	Нийт		900км

Авто машин: БОАЖГ-ын фургон 2292ТӨВ  
Нийт км, шатахуун 162 л А92 бензин 395000 төгрөг.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/693

Зуунмод

Намрын ойжуулалт хүлээж авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн ногоон зурвас, Хавар, намрын улиралд орон нутаг, аж ахуй нэгж байгууллагын хөрөнгөөр хийгдсэн ойжуулалтыг хүлээн авах ажлыг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Хавар, намрын ойжуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын удирдамжийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Дээрх ажилд шаардагдах зардал 1,053,320 (нэг сая тавин гурван мянга гурван зуун хорь) төгрөгийг аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т зөвшөөрсүгэй.

4.Ойжуулалт хийсэн талбайн газрын солбицлоор гаргаж, тухай бүр нь амьдралтын хувийг тооцож хүлээн авч, холбогдох тайланг гаргаж, танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Даш-яйчил)-д даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХБААТАР



Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 10 -ны өдрийн А/693 дүгээр  
захирамжийн 1 хавсралт



**ОЙЖУУЛАЛТ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга:

Ж.Даш-яйчил (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүдэд:

Ж.Отгонбуян (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч)

Ш.Гантулга (Батсүмбэр суман дахь сум дундын ойн ангийн дарга)

Ж.Гомбосүрэн (Лүн суман дахь сум дундын ойн ангийн дарга)

Ц.Дондогжамц (Лүн суман дахь сум дундын ойн ангийн ахлах мэргэжилтэн)

И.Даваанямбуу (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахмад ажилтан), (Зөвшилцсөнөөр)

Ж.Цэрэнжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

П.Төгсбилэгт (Аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан байцаагч Цагдаагийн дэслэгч)

Сумдын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Газрын даамал, байгаль хамгаалагчид хамтран гүйцэтгэнэ.

Нарийн бичгийн дарга:

Ц.Очирхуяг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн нэгжийн дарга)

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 10 -ны өдрийн А/693 дугаар  
захирамжийн 2 хавсралт



**ХАВАР, НАМРЫН УЛИРАЛД ХИЙГДСЭН ОЙЖУУЛАЛТЫН  
АЖЛЫГ ХҮЛЭЭН АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ**

2023.10.10

Зуунмод

Нэг: Зорилго.

Ойн тухай хууль болон холбогдох бусад журмын хэрэгжилтийг хангах тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн ойжуулалт, ногоон зурвас байгуулах ажлыг газар дээр шалгаж үнэлэлт өгч, мэргэжлийн удирдлага, зөвлөмжөөр хангаж ажиллахад удирдамжийн зорилго оршино.

Хоёр: Зорилт.

1.20 сая мод тарих аймгийн 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг шалгах, шинээр нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн га талбай, тарьц суулгацын тоог нэгтгэх.

2.Орон нутаг болон аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр 2023 онд хийгдсэн Ойжуулалт нөхөн сэргээлтийн ажлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт гаргах.

Гурав: Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.Аймгийн ИТХ-ын 2023 оны мод бэлтгэх хуваарь батлах тухай 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах, ойн тухай хуулийн хүрээнд мод бэлтгэл явуулсан аж ахуйн нэгж байгууллагуудын ойжуулалтыг газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргах

4.Аймаг, сумтай байгуулсан 2023 оны 20 сая мод тарих гэрээний хэрэгжилт явцыг шалгах

Дөрөв: Хамрах хүрээ.

Ойн бүхий 14 сум, Ойн мэргэжлийн байгууллага

Тав: Хугацаа.

2023 оны 10 дугаар сарын 18-аас 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд.

Зургаа: Хүрэх үр дүн.

Хууль, журмын хэрэгжилтэд үнэлэлт өгч, холбогдох арга хэмжээг газар дээр нь шийдвэрлүүлж, цаашид авч хэрэгжүүлэх бодлого чиглэлийг тодорхойлж хуулийн хэрэгжилт хангагдана.

Долоо :Явах чиглэл, хугацаа

1-р чиглэл:Алтанбулаг, Аргалант,Баянцогт, Баянхангай, Лүн, Заамар, Угтаалцайдам, Цээл, Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр, 2023 оны 10 дугаар сарын 16- нээс 11 дүгээр сарын 03 хүртэл 15 хоног.

2-р чиглэл:Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт 2023 оны 11 дүгээр сарын 06- нээс 15 хүртэл 8 хоног.

Маршрут-1:

№	Гарах	Хүрэх	км
Сумдаар явах чиглэл			
1.	Зуунмод	Алтанбулаг	51
2.	Алтанбулаг суман дотор		100
3.	Алтанбулаг	Аргалант	63
4.	Аргалант	Баянцогт	64
5.	Баянцогт суман дотор		100
6.	Баянцогт	Баянхангай	30
7.	Баянхангай	Лүн	32
8.	Лүн	Заамар	56
9.	Заамар суман дотор		100
10.	Заамар	Угтаалцайдам	56
11.	Угтаалцайдам	Цээл	23
12.	Цээл	Сүмбэр	83
13.	Сүмбэр	Жаргалант	36
14.	Жаргалант суман дотор		100
15.	Жаргалант	Борнуур	35
16.	Борнуур суман дотор		100
17.	Борнуур	Баянчандмань	33
18.	Баянчандмань	Батсүмбэр	54
19.	Батсүмбэр суман дотор		200
20.	Батсүмбэр	Зуунмод	122
21.	Нийт		1438

Авто машин: БОАЖГ-ын фургон 2292ТӨВ  
Нийт 1438 км, шатахуун 259 л А92 бензин 631,960.00 төгрөг. Тосоол 5л 35,000.00

Маршрут-2:

№	Гарах	Хүрэх	км
Сумдаар явах чиглэл			
1.	Зуунмод	Эрдэнэ	83
2.	Эрдэнэ суман дотор		150
3.	Эрдэнэ	Баяндэлгэр	25
4.	Баяндэлгэр	Мөнгөнморьт	92
5.	Мөнгөнморьт суман дотор		250
6.	Мөнгөнморьт	Зуунмод	194
7.	Нийт		794


Авто машин: БОАЖГ-ын фургон 2292ТӨВ  
Нийт 794 км, шатахуун 144 л А92 бензин 351,360.00 төгрөг Тосоол 5л 35,000.00

Найм: Дүн мэдээ гаргах тайлагнах.

Ажлын хэсэг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ цаашид авч хэрэгжүүлэх ажлын санал дүгнэлтээ боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Засаг дарга болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах

Удирдамж боловсруулсан:  
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
Ойн нэгжийн дарга  Ц.Очирхуяг

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 10 -ны өдрийн А/693 дугаар  
захирамжийн 3 хавсралт



ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ХҮЛЭЭН АВАХ ЗАРДЛЫН ТООЦОО.

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Шатахуун	литр	400	2440	983,320.00
2	Тосоол	литр	10	7,000	70,000.00
Нийт дүн					1,053,320.00

\_\_\_оОо\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/696

Зуунмод

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХРИАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэгийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Г.Сурмаа (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

А.Туяажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн Бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Ц.Нямгарав (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хяналтын инженер)

С.Мөнх-Амгалан (Зуунмод хотын Захирагчийн ажлын албаны Ахлах мэргэжилтэн)


Нарийн бичгийн дарга:

Э.Номин-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн)

2.Зуунмод сумын Унагалдайн андууд цэцэрлэгийн засварын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Сурмаа)-д ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Г.Сурмаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011809

My.Doc.zahiramj 2023-4 uliral



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/704

Зуунмод

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутагт дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>3</sup> дугаар зүйлийн 5<sup>3</sup>.1, 5<sup>3</sup>.2, 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилга, байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, техник, технологийн аюулгүй байдал, учирч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх “Барилга, байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” аяныг 2023 оны 10 дугаар сарын 18-аас 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Тус аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар, шаардагдах хөрөнгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Аяныг зохион байгуулахад шаардагдах шатахууны зардал 407,840 (дөрвөн зуун долоон мянга найман зуун дөчин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

4.Аяныг холбогдох газруудтай хамтран үр дүнтэй зохион байгуулж, нэгдсэн тайланг 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Барилга, хот байгуулалтын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

5.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д. МӨНХБААТАР

4123011840

Аймгийн Засаг дарга 2023 оны 10 дугаар сарын 18 -ны өдрийн АТТӨЗ дүгээр захирамжийн 1 хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.САРАН-ЭРДЭНЭ

(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлстийн дарга)

Гишүүд:

Д.АЛТАНСҮХ  
Б.БОЛОРМАА

(Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)  
(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

О.БААСАНХҮҮ

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч)

Ц.ЦЭВЭЛСҮРЭН

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар, геодези зураг зүйн хяналтын улсын байцаагч)

Ц.БАТХУЯГ

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

Ж.ОЮУНЦЭЦЭГ

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Ж.ХОСБАЯР

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Г.МЯГМАРСҮРЭН

(Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)

Б.ОЮУНЖАРГАЛ

(Стандарт хэмжилзүйн газрын Хэмжилзүйн хяналтын улсын байцаагч)

Д.ОЮУН

(Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга),(зөвшилцсөнөөр)

Ж.АДЪЯАБАЗАР

(Барилгачдын холбооны тэргүүн),  
(зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Б.НАСАНЖАРГАЛ

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Д.БАТЦЭЦЭГ

(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 18 -ны өдрийн А/ЗД дугаар  
захирамжийн 1 хэвсрэлт



## АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

### Нэг. Ажлын хэсгийн зорилго

Болзошгүй осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол улсын Хот байгуулалтын тухай, Барилгын тухай, Хөдөлмөрийн аюулгүйбайдал, эрүүлахуйн тухай, Эрчим хүчний тухай, Газрын тухай, Геодези, зураг зүйн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах, сурталчилан таниулах зорилготой.

Мөн барилга байгууламжийн чанар, стандарт, ажлын байранд тавигдах хөдөлмөрийнаюулгүйбайдал, эрүүлахуйн шаардлагыг хангуулах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч, иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, зөвлөн туслах, сургалт зохион байгуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Барилга, хот байгуулалтын сайдын "Барилга байгууламжийн угсралт, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулж ажиллах зарим арга хэмжээний тухай" 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 2021/01 дугаартай албан даалгавар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 07/02 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангуулахад тус тус оршино.

### Хоёр. Аяныг зохион байгуулах хугацаа

"Барилгын салбарын чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" аяныг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна.

### Гурав. Аяны хамрах хүрээ, хэрэгжүүлэх ажил:

3.1. Аянд барилгын салбарын захиалагч, зохиогч, гүйцэтгэгч, зөвлөх үйлчилгээ, төрийн болон төрийн бус байгууллагууд хамрагдана.

3.2. Ажлын хэсэг нь дараах ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. "Барилга байгууламжийн угсралт, чанар, аюулгүй байдал, эрүүл ахуй" аяныг зохион байгуулах, тайлан мэдээ гаргаж танилцуулах;

3.2.2. Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр зөвлөмж, постер, контент бэлтгэх, гарын авлага боловсруулах;

3.2.3. Барилга байгууламжийн угсралт, чанар, аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах зорилгоор сургалт зохион байгуулах;

3.2.4. Барилга байгууламжийн угсралт, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулж ажиллах зарим арга хэмжээний тухай" 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 2021/01 дугаартай албан даалгавар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 07/02 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангуулах;

3.2.5. Иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, түр хашаа, хаалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор "Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн

аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0301B:2022"стандартын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.2.6.Аймгийн нутаг дэвсгэрт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай 02/00/13, 07/00/08, 02/00/06, 07/001 дугаартай удирдамжуудын хүрээнд хийгдэж байгаа хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх;

#### Дөрөв. Аяны дүнг танилцуулах

4.1.Аяны үйл ажиллагааны явц байдал, тайлан, мэдээг сар тутам авч нэгтгэн дүгнэх, удирдлагуудад танилцуулах;

4.2."Барилгын салбарын чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" аяны нэгдсэн тайлан, танилцуулга бэлтгэх, үр дүнгийн талаар санал, дүгнэлт боловсруулах;

4.3.Аяны дүн мэдээг нэгтгэн гаргаж, нэгдсэн танилцуулга боловсруулж хүргүүлэх.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 1704 дугаар захирамжийн 3 хавсралт



"БАРИЛГЫН САЛБАРЫН ЧАНАР, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ" АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсөв
Нэг. Зохион байгуулалтын ажлын хүрээнд					
1.1	"Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" аян зохион байгуулах, хамтран ажиллах байгууллага, холбогдох мэргэжилтэн, улсын байцаагчдын уулзалт хийх	2023.10.02	ГХБХБГ	ХОХБХ СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	-
1.2	"Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" аяны үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөө боловсруулж батлуулах	2023.10.06	ГХБХБГ ХХҮГ	ХОХБХ СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	-

1.3	Аяны үйл ажиллагааны явц байдал, тайлан, мэдээг сар тутам нэгтгэн хүргүүлэх	2023.09.25 2023.10.25 2023.11.25	ГХБХБГ ХХҮГ	ХОХБХ СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	-
1.4	"Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" аяны нэгдсэн тайлан, танилцуулга, үр дүнгийн талаар санал, дүгнэлт боловсруулан БХБЯ, ХНХЯ-д хүргүүлэх	2023.11.01 - 2023.11.30	ГХБХБГ ХХҮГ	ХОХБХ,СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	-
Хоёр.Зөвлөмж, постер, гарын авлага боловсруулах ажлын хүрээнд					
2.1	Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр зөвлөмж боловсруулж хүргүүлэх	2023.09.01 - 2023.11.30	ГБХБХГ ХХҮГ	ХОХБХ ХХҮГ СХГ ГБХБХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	-
2.2	Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомж, норм дүрэм, журам, стандартыг сурталчилсан шторк, постер бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, page хуудсаар олон нийтэд хүргэх	2023.09.01 - 2023.11.30	ГХБХБГ ХХҮГ	ХОХБХ СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	-
2.3	ОУХБ-ын Барилгын салбар дахь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 167 дугаар конвенцийг олон нийтэд сурталчлах	2023.09.01 - 2023.11.30	ГХБХБГ ХХҮГ		-

2.4	Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	2023.09.01 - 2023.11.30	ГХБХБГ  ХХҮГ	ХОХБХ СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	Улсын болон орон нутгийн төсөв
Гурав.Урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах ажлын хүрээнд					
3.1	Барилгын салбарын ажил олгогч, ИТА нарт зориулсан "Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах нь" сэдэвт сургалтад аймгийн барилгын салбарын аж ахуйн нэгжүүдийг хамруулах	2023.09.01 - 2023.11.30	Аймгийн Барилгачдын холбоо	ГХБХБГ	
3.2	"Барилгын материалын чанар хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь" сэдэвт сургалт зохион байгуулна	2023.10.18 -20	Эрүүл мэндийн газар	ГХБХБГ ХХҮГ	Улсын болон орон нутгийн төсөв
3.3	"Барилгынсалбарынажилчдынхөдөлмөрлөхэрх" сэдвээржилтнуудадсургалтзохионбайгууна	2023.10.17 -19	Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо	ГХБХБГ ХХҮГ	Улсын болон орон нутгийн төсөв
3.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээжийн байдал дүзлэх хийх	2023.10.01 - 2023.11.30	ГХБХБГ ХХҮГ	ХОХБХ БЗОСК /ОНӨААТҮГ/	
Дөрөв.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлын хүрээнд					
4.1	Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	2023.09.01 - 2023.11.20	ГХБХБГ  ХХҮГ	ХОХБХ СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	Улсын болон орон нутгийн төсөв

4.2	Иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, түр хашаа, хаалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор "Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0301B:2022" стандартын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	2023.09.01 - 2023.11.20	ГХБХБГ ХХҮГ БЗОСК ОНӨААТҮГ	ХОХБХ СХГ	Улсын болон орон нутгийн төсөв
4.3	Барилга, хот байгуулалтын сайдын "Барилга байгууламжийн угсралт, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулж ажиллах зарим арга хэмжээний тухай" 2022 оны 04 дүгээрсарын 07-ны өдрийн 2021/01 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангуулах	2023.09.01 - 2023.11.30	ГХБХБГ	ХОХБХ СХГ БЗОСК /ОНӨААТҮГ/	-
4.4	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 07/01, 07/02 дугаартай албан даалгаврын биелэлтийг хангуулах	2023.09.01 - 2023.11.30	ХХҮГ	Барилгачдынхо лбоо ААНБ	-
4.5	Аймгийн хэмжээнд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй объектын судалгаа гаргах	2023.09.08	ГХБХБГ ХХҮГ	БЗОСК /ОНӨААТҮГ/	-
4.6	Зөвшөөрөлгүй баригдсан болон зогссон, хамгаалалтын горимд шилжсэн барилга байгууламжийн нэгдсэн судалгаа гаргах	2023.10.01 - 2023.10.30	ГХБХБГ	ХОХБХ БЗОСК /ОНӨААТҮГ/	-

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 18 -ны өдрийн 11/204 дүгээр  
захирамжийн 4 хэвсрэлт



АЖЛЫН ХЭСГИЙН СУМДАД АЖИЛЛАХ ШАТАХУУНЫ ТООЦОО

№	Чиглэл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Зуунмод-Бүрэн-Зуунмод	Литр	65	2440	158 600
2	Зуунмод-Борнуур-Жаргалант- Заамар-Зуунмод	Литр	96	2440	234240
3	Зуунмод-Сэргэлэн-Зуунмод	Литр	6	2440	14 640
	Дүн		158	2440	407 480

\_\_\_оОо\_\_\_



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/705

Зуунмод

Зөвлөл байгуулж, төлөвлөгөө  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3., 2.6 дэх заалт, БШУС, ЭМС, ХНХС-ын А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар, салбар хоорондын уялдааг хангах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих аймгийн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих аймгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр ханган, шаардлагатай төсвийг жил бүрийн төсөвт тусган, хяналт тавьж ажиллахыг Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих зөвлөл (Д.Мөнхцэцэг)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар  
сарын 18-ны өдрийн 4765 дүгээр  
захирамжийн 1 хавсралт



**БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭГ  
НЭГДСЭН УДИРДЛАГА, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАХ ОРОН ТООНЫ БУС  
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**

-Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

**ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:**

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн:

-Жендэрийн эрх тэгш байдал, салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

-Боловсрол, шинжлэх ухааны бодлого хариуцсан мэргэжилтэн

-Эрүүл мэндийн бодлого хариуцсан мэргэжилтэн

-Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

-Боловсрол, шинжлэх ухааны газрын Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн

-Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, зорилтот бүлгийн хүн ам, өрхийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

-ДЗОУБ-ын Төв орон нутгийн хөтөлбөрийн менежер

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны тэргүүн

**ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:**

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

(2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл)

-Эрүүл мэндийн газрын дарга

(2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл)

-Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

(2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл)

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 1/2023 дугаар захирамжийн 2 хавсралт



БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АЙМГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ(2023-2026)

БОДЛОГО, ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ УЯЛДАА	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, /ХЭМЖИХ НЭГЖ/	СУУРЬ ТУВШИН /2022 ОН/	ХҮРЭХ ТҮВШИН	ХУГАЦАА /ОН/	ХАРИУЦАН ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА	ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА
зорилт 1. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үйлчилгээний үр ашигтай нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх							
-АЗДҮАХ, -Эрүүл эхээс- Эрүүл хүүхэд хөтөлбөр, -Хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөр	1.1. Аймгийн Засаг даргын дэргэд Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах орон тооны бус зөвлөл байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулах	-Удирдлагын шийдвэр -Төлөвлөгөө	-	Орон тооны бус орон нутгийн зөвлөл Засаг даргын дэргэд байгуулагдсан байна.	2023-2024	БШУГ	ЭМГ, ХХҮГ, ХГБХХГ
	1.2 Орон тооны бус орон нутгийн зөвлөлийн ажиллах дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах уулзалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	-Зөвлөлийн ажиллах дүрэм, -Үйл ажиллагааны төлөвлөгөө	-	-Зөвлөлийн ажиллах дүрэм, -Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагд ан батлагдсан байх	2023	БШУГ	ЭМГ, ХХҮГ, ХГБХХГ
	1.3. Бага насны хүүхдийн аж байдлын судалгаа	Судалгааны тайлан	-Эрсдэлт нөхцөлд	Судалгааг хийж, тайлан	2024-2025	ХГБХХГ	БШУГ, ЭМГ

	хийж, үр дүнг бодлого, төлөвлөлтөд ашиглах		байгаа хүүхдийн судалгаа	зөвлөмж боловсруулсан байна.			
	1.4. "Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжиххөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах	Төлөвлөгөө, тайлан	-	Хяналтад авч тайлагнадаг байна		ЭМГ	ХГБХХГ БШУГ
	1.5. Нийгмийн хариуцлагын хүрээнд хувийн хэвшил, бусад байгууллагаас бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх санаачилгыг дэмжих	Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн байгууллагын тоо, Хөрөнгө оруулалтын хэмжээ /төг/	ДЗОУБ-ын Төв орон нутгийн хөгжлийн хөтөлбөр	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалт жил бүр нэмэгдүүлсэн байна.	2023-2026	ХХҮГ, ХГБХХГ БШУГ, ЭМГ,	Олон нийтийн байгууллага
<b>ЗОРИЛТ 2. ГЭР БҮЛ, ОЛОН НИЙТЭД СУУРИЛСАН ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ</b>							
-АЗДҮАХ, "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөр	2.1. 0-3 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйлчилгээнд хамрагдсан 0-3 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлийн тоо	-80 гэр бүл	Жил бүр 0-3 хүртэлх насны хүүхэдтэй 100-аас доошгүй гэр бүлд үйлчилгээ, дэмжлэг үзүүлсэн байна.	2023-2026	ХГБХХГ	Олон нийтийн байгууллага, иргэд
	2.2 3-6 хүртэлх настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж, цогц хөгжлийг дэмжих	3-5 насны нийт хүүхдэд үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	88.0 хувь	2023 онд 89 2024 онд 90.0 2025 онд 91.0 2026 онд 92.0	2023-2026	БШУГ	СӨББ
	2.4. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг,	Зохион байгуулсан	Бага насны	Эцэг, эх, асран хамгаалагчдыг	2023-2024	БШУГ	ХГБХХГ, ЭМГ

	эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	арга хэмжээний тоо хамрагдсан хуний тоо.	хүүхдийн цогц, хөгжлийг дэмжих чиглэлээр 1 сургагч багш бэлтгэсэн	чадавхжуулах чиглэлээр 3-аас доошгүй сургалт зохион байгуулж, 300-аас доошгүй хүнийг хамруулсан байна.	2023-2026	БШУГ ХГБХХГ	Байгууллага, ААН, иргэд ЕБС, СӨББ, МББ
2.5.	Бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжих, ажлын цагийн болон "хүүхэд асрах чөлөө"-ний уян хатан зохицуулалт хэрэгжүүлэх зэрэг хүүхэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ тогтмол зохион байгуулах	Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлдэг аж ахуй нэгж, байгууллагын тоо	ХНХ-ын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар Хүүхдэд 78- *хамгааллын бодлого хэрэгжүүл дэг аж ахуй нэгж, байгууллагын тоо 33 байна.	Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын тоог жил бүр өмнөх оноос 10-15 хувиар нэмэгдүүлсэн байна.		ХГБХХГ	Байгууллага, ААН
-АЗДУАХ -"Эх, хүүхэд,	2.6. Бага насны хүүхэдтэй ажилтанд	Сургалт, зөвлөгөө,	Байгууллагын аж ага,	Жил бүр 30-аас доошгүй	2023-2024	ХГБХХГ	Байгууллага, ААН

<p>НҮЭМ” арга хэмжээний төлөвлөгөө</p> <p>“Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд” хөтөлбөр</p>	<p>зориулан хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсгөн бойжуулах, хөгжлийг дэмжих талаар сургалт, зөвлөгөө өгөх ажлыг байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах</p>	<p>нөлөөллийн арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо</p>	<p>ахуйн нэгжийн дэргэдэх 218 эцэг эхийн зөвлөл ажиллаж, 3005 албан хаагчдыг сургалтад хамруулс ан.</p>	<p>сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 3000-аас доошгүй хүнийг хамруулсан байна</p>	<p>2023-2023</p>	<p>ЭМГ</p>	<p>Сум, өрхийн ЭМТ, АНЭ Олон нийтийн байгууллага, иргэд</p>
<p>2.7. Эхийн хэвлийд ураг бүрэлдэх үеэс эхлэн 1000 хоногийн хугацаанд хүүхдийн хөгжлийг хянах, өсөлтийг дэмжих, эх, хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл, асаргаа, хамгааллын чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах нөлөөллийн ажиглалаа үйл зохион байгуулах</p>	<p>Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан эцэг, эх, асран хамгаалагчдын хувь</p>	<p>15 арга хэмжээ зохион байгуулж, 2000 /18.8%/ гаруй эцэг, эхэд зөвлөгөө мэдээлэл өгсөн</p>	<p>2023 онд 20-ээс дээш 2024 онд 25-ээс дээш 2025 онд 30-ээс дээш 2026 онд 35-ээс дээш</p>	<p>2023-2026</p>	<p>ЭМГ, Сум, өрхийн ЭМТ</p>	<p>ЭМГ, өрхийн ЭМТ, АНЭ Олон нийтийн байгууллага, иргэд</p>	
<p>2.8. Өрх, сумын Эрүүл мэндийн төвөөс хүүхдэд үзүүлэх “Гэрийн эргэлт”-ийг эх, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн өсөлт, хөгжил, хамгаалалд чиглэсэн цогц үйлчилгээ хэлбэрээр олон нийтийн оролцоонд түшиглэн</p>	<p>Гэрийн эргэлтэд хамрагдсан 1 хүртэлх насны хүүхдийн хувь</p>	<p>Гэрийн эргэлтэд хамрагдс ан 1 хүртэлх насны хүүхдийн хувь-70</p>	<p>Жил бүр 1.0 хувиар нэмэгдүүлнэ.</p>	<p>2023-2026</p>	<p>ЭМГ, Сум, өрхийн ЭМТ</p>	<p>ЭМГ, Олон нийтийн байгууллага, иргэд</p>	

	<p>2.9. Бага насны хүүхдийг эрүүл мэнд, хөгжлийн эрт илрүүлэх үзлэг, хөгжлийн хяналт, дархлаажуулалтад тогтмол хамруулах зан үйлийг эцэг эх, асран хамгаалагчдад хэвшүүлэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх</p>	<p>Хөгжлийн эрт илрүүлэх үзлэг, хөгжлийн хяналт, дархлаажуулалт ад хамрагдсан 0-5 хүртэлх насны хүүхдийн хувь</p>	<p>Дархлаажуулалтад хамрагдсан 0-5 хүртэлх насны хүүхдийн хувь 96%</p>	<p>2023 онд 96,0 хувь 2024 онд 96,3 хувь 2025 онд 96,5 хувь 2026 онд 96,8 хувь</p>	<p>2023-2026</p>	<p>ЭМГ, Өрх, сумын ЭМТ</p>	<p>ЭМГ, Эцэг, эх, асран хамгаалагчид</p>
<p>-“Эх, хүүхэд, НҮЭМ” арга хэмжээний төлөвлөгөө -АЗДУАХ</p>	<p>2.10. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж, хоцролттой болон хоцролт үүсэх эрсдэлтэй хүүхдэд зориулсан тусгай дэмжлэг, эрт үеийн оролцооны хөтөлбөрийг олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх</p>	<p>Олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлсэн эрт үеийн оролцооны үйл ажиллагааны тоо</p>	<p>-Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамралт 48,5%</p>	<p>Олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлсэн эрт үеийн оролцооны үйл ажиллагааны тоо нэмэгдэнэ.</p>	<p>2023-2026</p>	<p>ЭМГ, Сум, өрхийн ЭМТ</p>	<p>ЭМГ, Олон нийтийн байгууллага, иргэд</p>
<p>-“Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд” хөтөлбөр</p>	<p>2.11. Жирэмсэн үеийн хяналт, эхийн эрүүл мэнд, бага насны хүүхдийн хөгжлийг гэр бүлийн орчинд дэмжихэд хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчдад зориулсан ном, гарын авлага, хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн багц, сургалтын модуль, контент, нээлттэй платформ, аппликэйшн хөгжүүлэх. Энэ чиглэлээр бий болсон</p>	<p>Арга хэрэгслийг хөгжүүлсэн үр дүн</p>	<p>Жирэмсэн эхчүүдэд зориулсан хяналтын нэг аппликэйшн ашигладаг</p>	<p>Хүүхдийг ургийн үеэс эхлэн эрүүл бийжүүлэх, гэр бүлийн орчинд хөгжлийг нь дэмжих чиглэлээр бодит болон</p>	<p>2023-2024</p>	<p>ЭМГ</p>	<p>ЭМГ, Олон нийтийн байгууллага, иргэд</p>

	<p>Сургалтын модуль, контент, нээлттэй платформ, аппликейшн хөгжүүлэх энэ чиглэлээр бий болсон санаачилгыг дэмжих</p>			<p>Цахим хэрэглэгдэхүүн, ном гарын авлагыг сонголттойгоор ашиглах боломж бүрдэнэ.</p>			
<p>-“Эх, хүүхэд, нүэм” арга хэмжээний төлөвлөгөө -АЗДУАХ -“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр</p>	<p>2.13. Гэр бүлд суурилсан хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанаас цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд шилжих бэлэн байдал, дасан зохицоход чиглэсэн дэмжлэг үзүүлэх</p>	<p>Зохион байгуулсан үйл ажиллагааны хэлбэр, хамрагдсан хүүхдийн хувь</p>	<p>СӨБ-ын бэлтгэл бүлгийн /5 нас/ хамралт -93%</p>	<p>Гэр бүлийн орчноос сургалтын байгууллагын орчинд шилжиж буй хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа тогтмолжино.</p>	<p>2023-2026</p>	<p>БШУГ</p>	<p>ЕБС, Цэцэрлэг</p>
	<p>2.14. Гэр бүл төлөвлөлт, эхийн эрүүл мэнд, хүний амьдралын эхний 1000 хоног, хүүхдийг эхийн сүүлээр хооллох, хүүхдийн эрт үеийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, сургуульд бэлтгэх, байгальд ээлтэй, амьдралын хэв маягт сурах зэрэг асуудлаар эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хандлага,</p>	<p>Олон нийтэд чиглэсэн арга хэмжээний тоо, төрөл</p>	<p>Гэрийн эргэлт-70%, Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг-48,5%, Цахим мэдээлэл 8, хандалт 51200</p>	<p>Олон нийтэд чиглэсэн арга хэмжээг жил бүр Давтамжтай зохион байгуулна.</p>	<p>2023-2025</p>	<p>ЭМГ, ХГБХХГ, ХХҮГ, БШУГ</p>	<p>Олон нийтийн байгууллага</p>

	зан үйлийг хэвшүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах						
	2.15. Номын сан, хүүхдийн тоглоомын төв, музей, кино театр, худалдаа, үйлчилгээний болон спорт, чийрэгжүүлэлтийн төвд хүүхдийн хөгжлийг дэмжих ээлтэй орчин бүрдүүлэх	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн ААН-ийн тоо	-Аймгийн ННС, Музейд ээлтэй орчин бүрдүүлсэн	Үйлчилгээний газруудад хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжих ээлтэй орчин бүрдэнэ.	2023-2026	ХГБХХГ, БШУГ, ЭМГ, БТСГ, СУГ	ААНБ, Салбар зөвлөл
<b>ЗОРИЛТ 3. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ</b>							
	3.1. Бага насны хүүхэдтэй ажиллах хүний нөөцөд тавих шаардлага болон хүний нөөцийг бэлтгэх, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	Хүний нөөц бэлтгэх сургалтын хөтөлбөр	АШЭМБ-ын эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт 3төрөл 265 хүн хамрагдсан	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний ажилтан хүүхэд асрагч/-д тавих шаардлага, бэлтгэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2024	БШУГ	ТАСЗ, ХХҮГ, ХГБХХГ, ЭМГ, Сумдын ЗДТГ
	3.2. Бага насны хүүхдэд эруул мэнд, хоол тэжээл, асаргаа, хамгаалал, хөгжил, боловсролын үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх	Бэлтгэгдсэн хүүхэд асрах ажилтны тоо	-	2023 онд – Аймгийн хоол тэжээлийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулна.	2023-2026	БШУГ ХХҮГ ХГБХХГ ЭМГ	БТСГ, Сумдын ЗДТГ
-“Эх, хүүхэд, НҮЭМ” арга хэмжээний төлөвлөгөө	3.3 Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтныг нярайн эрт үеийн оношилгоо, хүүхдийн	Зохион байгуулсан сургалт, үйл ажиллагаа, хамрагдсан	АШЭМБ-ын 75 мэргэжилтнийг 1 удаа	Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтныг	2023-2026	ЭМГ	Өрх, сумын ЭМТ, Сумдын ЗДТГ

-“Эрүүл эхээс- Эрүүл хүүхэд” хөтөлбөр	цогц хөгжлийн үзүүлэлтийг хянах арга зүйд сургах, чадавхыг дэмжих	ажилтны тоо	сургалтад хамруулсан	нярайн эрт үеийн оношилгоо, хүүхдийн цогц хөгжлийн үзүүлэлтийг хянах арга зүйд сургах сургалтыг жил бүр зохион байгуулсан байна.			
	3.4. Эцэг, эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх сайн дурын ажилтан, сургагч багшийг бэлтгэж тогтвортой ажиллуулах	Сайн дурын ажилтны тоо	Сайн дурын ажилтныг бүртгэх цахим бүртгэлийн системийн хөгжүүлэлт хийсэн	Жил бүр 5-аас доошгүй сайн дурын ажилтан бэлтгэж, ажиллуулсан байна.	2023-2024	ХГБХХГ ЭМГ БШУГ	Сумдын ЗДТГ, Олон нийтийн байгууллага
<b>ЗОРИЛТ 4. БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦ ХӨГЖЛИЙГ ХЯНАХ САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОХ</b>							
	4.1. Хүүхэд бүрийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг хянах үзүүлэлт, аргачлал, хяналтын хуудсыг боловсруулж, хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц хяналтыг 9,18,36,60 сартайд хийж, мэдээллийн системд бүртгэх	Хяналтад хамрагдсан 9,18, 36, 60 сартай хүүхдийн хувь	9. 18 сартай хүүхдийн хамралтын хувь 85,0 хувь	Жил бүр 5,0 хувиар нэмэгдүүлнэ.	2023-2026	ЭМГ	Өрх, сумын ЭМТ
	4.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн	Уулзалт хэлэлцүүлэгт	-	Уулзалт хэлэлцүүлэгт	2023-2026	Зөвлөл	ХБХЭМБНХСК

	эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг нүүдлийн болон цахим хэлбэрээр зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн уулзалт хэлэлцүүлэг, сэтгэл зүйн сургалтуудыг зохион байгуулна.	хамрагдсан эцэг эхийн тоо		хамрагдсан эцэг эхийн тоо 270			
4.3	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, хувилбарт сургалтад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах бодлогыг хэрэгжүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хамрагдалтын хувь	52.65%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хамрагдалтын хувь 59%-70%	2023-2026	БШУГ	ГБХЗХГ, ХХҮГ, ЕБС, СӨБ, Дэмжлэгийн баг



## ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/707

Зуунмод

### Ажлын хэсэг томилж, зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.17, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны 300 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Засаг даргын Тамгын газар болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 10-ны өдрийг дуустал зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Хяналт-шинжилгээ, үнэлгээ”-ний ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын томилолтын зардлыг тухайн байгууллагаас олгохыг холбогдох хэлтэс, агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3. “Хяналт-шинжилгээ, үнэлгээ” хийх ажлын хэсгийн томилолт, шатахууны зардалд шаардагдах 10,844,650 (арван сая найман зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат)-т даалгасугай.

4. Захирамжийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Т.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дүгээр сарын 30 -ны өдрийн 1707 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт



“ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ”-НИЙ БАГТ АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2023.10.30

Зуунмод

№	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Ажиллах сумд	Маршрут
1	2	3	4
1	<p>Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч Г.Сурмаа</p> <p>Гишүүд: Б.Оюунцэцэг (ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн) А.Доржпүрэв (ХЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн) Ж.Батчимэг (ХБТХОХ-ийн мэргэжилтэн) Э.Лхагвадулам (НБХ-ийн ахлах мэргэжилтэн) Н.Батбаяр (СХДАА-ны СХШУ-ын байцаагч)</p> <p><u>Зуунмод суманд нэмэлт ажлын хэсэг:</u> Б.Мягмарсүрэн (НБХ-ийн мэргэжилтэн) Д.Амаржаргал (БШУГ-ын мэргэжилтэн)</p>	<p>Зуунмод Сэргэлэн Алтанбулаг</p>	<p>ЗМ – СЭ : 14 км СЭ – ЗМ : 14 км ЗМ – АБ : 51 км АБ – ЗМ : 51 км</p> <p>Бүгд 130+150=280 км</p>
2	<p>Ажлын хэсгийн ахлагч: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга С.Магнайбаяр</p> <p>Гишүүд: Д.Сэдэд (ХЭЗХ-ийн мэргэжилтэн) Б.Цэрэнлхагва (ТЗУХ-ийн мэргэжилтэн) С.Бүжмаа (ЭМГ-ийн албаны дарга) Б.Баярсайхан (ОНӨГ-ын ахлах мэргэжилтэн) А.Ариунбаяр (СХДАА-ны дотоод аудитор, СХШУ-ын ахлах байцаагч)</p>	<p>Баянжаргалан Баян Баянцагаан Баян-Өнжүүл</p>	<p>ЗМ – БЖ : 141 км БЖ – БН : 63 км БН – БЦ : 67 км БЦ – БӨ : 106 км БӨ – ЗМ : 131 км</p> <p>Бүгд 508+160=668 км</p>
3	<p>Ажлын хэсгийн ахлагч: Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Ганхуяг</p> <p>Гишүүд: Б.Одончимэг (Төсвийн ерөнхий нягтлан бодогч) Б.Мөнхбат (ХШҮХ-ийн ахлах мэргэжилтэн) Г.Оюун-Эрдэнэ (ХЭЗХ-ийн мэргэжилтэн) Б.Батболд (ХБТХОХ-ийн мэргэжилтэн) Г.Чанцалдулам (НБХ-ийн мэргэжилтэн)</p>	<p>Сүмбэр Жаргалант Борнуур Батсүмбэр</p>	<p>ЗМ – СУ : 206 км СУ – ЖА : 36 км ЖА – БР : 50 км БР – БС : 120 км БС – ЗМ : 122 км</p> <p>Бүгд 534+160=694 км</p>
4	<p>Ажлын хэсгийн ахлагч: Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт</p> <p>Гишүүд: А.Туяажаргал (ХБТХОХ-ийн ахлах мэргэжилтэн) М.Доржмаа (ТЗУХ-ийн мэргэжилтэн) Д.Батцэнгэл (БШУГ-ын ахлах мэргэжилтэн) Т.Билгүүн (ЭМГ-ын мэргэжилтэн)</p>	<p>Мөнгөнморьт Баяндэлгэр Эрдэнэ Архуст</p>	<p>ЗМ – ММ : 194 км ММ – БД : 92 км БД – ЭР : 25 км ЭР – АХ : 30 км АХ – ЗМ : 113 км</p> <p>Бүгд 454+160=614 км</p>

5	<p>Ажлын хэсгийн ахлагч: Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Т.Хуягбаатар</p> <p>Гишүүд: А.Хажидмаа (НБХ-ийн ахлах мэргэжилтэн) П.Дэмчигжав (ХБТХОХ-ийн мэргэжилтэн) Д.Бадамсүрэн (ХШҮХ-ийн мэргэжилтэн) Н.Оюун-Эрдэнэ (СТСХ-ийн мэргэжилтэн)</p>	<p>Лүн Заамар Цээл Угтаалцайдам</p>	<p>ЗМ – ЛН : 175 км ЛН – ЗА : 56 км ЗА – ЦЭ : 79 км ЦЭ – УЦ : 23 км УЦ – ЗМ : 199 км Бүгд 532+160=692 км</p>
6	<p>Ажлын хэсгийн ахлагч: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг</p> <p>Гишүүд: Л.Цэрэнноров (ХЭЗХ-ийн мэргэжилтэн) Д.Энхжаргал (СТСХ-ийн мэргэжилтэн) Ц.Баярмагнай (ХБТХОХ-ийн мэргэжилтэн) Г.Сувдаа (НБХ-ийн мэргэжилтэн)</p>	<p>Аргалант Баянхангай Баянцогт Баянчадмань</p>	<p>ЗМ - АР : 131 км АР – БХ : 34 км БХ – БЦ : 30 км БЦ – БЧ : 43 км БЧ – ЗМ : 111 км Бүгд 349+160=509 км</p>
7	<p>Ажлын хэсгийн ахлагч: Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Батжаргал</p> <p>Гишүүд: Н.Хорлоо (СТСХ-ийн мэргэжилтэн) Б.Амармэнд (ТЗУХ-ийн мэргэжилтэн) М.Туяа (ХХААГ-ын Албаны дарга) Т.Нямсүрэн (ЭМГ-ын НЭМХ-ийн дарга) Б.Оюунсайхан (БШУГ-ын мэргэжилтэн)</p>	<p>Бүрэн Дэлгэрхаан Эрдэнэсант Өндөрширээт</p>	<p>ЗМ – БҮ : 192 км БҮ – ДХ : 54 км ДХ - ЭС : 68 км ЭС - ӨШ : 35 км ӨШ - ЗМ : 231 км Бүгд 580+160=705 км</p>

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ХУЯГБААТАР

ХУВААРЬ ГАРГАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЯРЦЭЦЭГ

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дүгээр сарын 30 -ны өдрийн А/702 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт



“ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ”-НИЙ БАГИЙН  
ЗАРДЛЫН ТООЦОО

2023.10.30

Зуунмод

№	Зардлын зүйл		Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2		3	4
1	I ажлын хэсэг (Старекс)	шатахуун	280 км 100 км-т 17л (А-92)*3750₮	178,500
		томилолт	5 хүн*2 хоног 64000	640,000
2	II ажлын хэсэг АЗДТГ (Старекс 4618 ТӨА)	шатахуун	705 км 100 км-т 17л (АИ-92) *3750₮	449,440
		томилолт	3 хүн*4 хоног 64000	768,000
3	III ажлын хэсэг АИТХ-ын ажлын алба (Hiase 0049 ТӨҮ)	шатахуун	692 км 100 км-т 17л (дизель) *3750₮	441,150
		томилолт	6 хүн*4 хоног 64000	1,536,000
4	IV ажлын хэсэг СХДАА (Старекс 8849 ТӨА)	шатахуун	694 км 100 км-т 17л (дизель) *3750₮	442,430
		томилолт	3 хүн*4 хоног 64000	768,000
5	V ажлын хэсэг АЗДТГ (Старекс 9299 ТӨВ)	шатахуун	614 км 100 км-т 17л (дизель)*3750₮	391,430
		томилолт	5 хүн*4 хоног 64000	1,280,000
6	VI ажлын хэсэг АЗДТГ (Дэлика-Д5 9982 ТӨА)	шатахуун	509 км 100 км-т 17л (дизель) *3750₮	324,490
		томилолт	5 хүн*4 хоног 64000	1,280,000
7	VII ажлын хэсэг ХХҮГ (Старекс 9299 ТӨВ)	шатахуун	667 км 100 км-т 17л (дизель)*3750₮	425,210
		томилолт	2 хүн*4 хоног 64,000	512,000
10	Жолооч	томилолт	5 хүн*4 хоног 64,000	1,280,000
		томилолт	1 хүн * 2 хоног 64,000	128,000
Шатахууны нийт дүн				2,652,640
Томилолтын нийт дүн				8,192,000
Нийт дүн				10,844,650

ХЯНАСАН:  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ж.ЭРДЭНЭЖАРГАЛ

ХУВААРЬ ГАРГАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН Ц.БАЯРЦЭЦЭГ



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/710

Зуунмод

Мотоциклийн хөдөлгөөнийг  
түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд аймгийн нутаг дэвсгэрт мотоциклтой замын хөдөлгөөнд оролцохыг түр хугацаагаар хориглосугай.

2.Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүн, явц байдал, цаашид авах арга хэмжээний саналыг танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэд орон нутгийн засаг захиргаанд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга сэрэмжлүүлэг өгч, сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай хүргэж зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллахыг аймаг дахь Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4123011858



## ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/716

Зуунмод

“Цахим-Төв аймаг” хөтөлбөр  
боловсруулах ажлын хэсэг  
шинэчлэн байгуулах тухай

“Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II хуралдааны 01 дүгээр тогтоолын 5.3 дахь “Цахим Төв аймаг” бүлэг, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны III хуралдааны 01 дүгээр тогтоолын 7.1 дэх “Цахим төрийн үйлчилгээ” бүлэг, “Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны VII хуралдааны 01 дүгээр тогтоолын 7.1 дэх заалтын “Цахим-Төв аймаг төслийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ” гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Цахим-Төв аймаг” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

С.Магнайбаяр

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Ганхуяг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Саран-Эрдэнэ

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ю.Бямбацогт

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Т.Хуягбаатар

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Д.Мөнхцэцэг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Т.Тулга

(Төв аймгийн Цахилгаан холбооны газрын дарга)

Т.Ариунболд

(Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ийн Төв аймаг дахь газрын дарга)

А.Бурмаа

(Харилцаа холбооны хяналтын Улсын байцаагч)

Э.Ганхуяг

(Төрийн үйлчилгээний мэдээллийн төвийн ажилтан)

4123011870

My.Doc.zahiramj 2023-4 uliral

Б.Баднаанямбуу	(Төрийн үйлчилгээний мэдээллийн төвийн ажилтан)
Ө.Энхмөрөн	(Цагдаагийн газрын холбооны инженер, дэд Ахлагч)
А.Мөнхбаатар	(Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан)
Ц.Бямбасүрэн	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн)
Г.Баярбаатар	(Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн)
Э.Төрбат	(Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээлэл технологи, сургалт хариуцсан мэргэжилтэн)
Б.Гансүх	(Боловсрол, шинжлэх ухааны газрын Математик, физик, мэдээллийн технологийн сургалт хариуцсан мэргэжилтэн)
Э.Билгүүн	(Эрүүл мэндийн газрын мэдээлэл технологи, цахим мэдээлэл хариуцсан ажилтан)
Ц.Хосбаяр	(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн программ хангамжийн мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн)
Б.Доржнямбуу	(Аймгийн нэгдсэн эмнэлгийн мэдээллийн технологийн инженер)
П.Цолмонбаатар	(Авто тээврийн төвийн хяналтын мэргэжилтэн)
С.Цэрэндэжид	(Төв Чандмань-ДЭХГ ОНӨААТҮГ-ын инженер)
М.Батбаяр	(Аймгийн холбооны газрын Ахлах инженер)
Ц.Жандаг	(Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн Төв аймгийн газрын сүлжээний инженер)
Д.Одонтунгалаг	(Төв аймгийн Шүүхийн мэдээлэл технологийн мэргэжилтэн)
Г.Хатанбаатар	(Төв аймгийн Татварын хэлтсийн мэдээлэл технологийн мэргэжилтэн)
Б.Эрдэнэ-очир	(Төв аймгийн Тагнуулын газрын мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	
Ц.Ууганбаатар	(Төв аймаг Төрийн Цахим Үйлчилгээний хэлтсийн дарга)

2.“Цахим-Төв аймаг” хөтөлбөрийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн зөвлөмж, шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2023 оны IV улиралд багтаан танилцуулахыг Ажлын хэсэг (М.Отгонбат)-т даалгасугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны “Цахим-Төв аймаг” төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулах тухай А/164 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР